



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/199/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn

Аудитор : Э.Бат-Эрдэнэ
Утас:261740 Цахим хаяг: baterdene@audit.gov.mn

Ажу мэргэн аудит ХХК-ийн захирал: Л.Насанбуян
Утас:99093142 Цахим хаяг: Ajumergenaudit.mon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТРЫН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.АЛТАНХУЯГ
ТАНАА

2025.02.25 № 07/698
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дуурь бүжгийн эрдмийн театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 306,465.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2 дахь заалт, Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалын нэг дэх заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Монголын балетийн хөгжил сангаас Дуурь бүжгийн эрдмийн театр Цөмөөхэй хүүхдийн жүжгэн балетийн тоглох эрхийг, жүжигчдийн хэрэглэж байсан хувцас, тайзны жижиг хэрэглэлүүдийн хамт үнэ төлбөргүй хүлээлгэж өгсөн байна.

Цөмөөхэй хүүхдийн жүжгэн балетийн жүжигчдийн хэрэглэж байсан хувцас, тайзны жижиг хэрэглэлүүдийг нэр төрлөөр нь комисс гарган хүлээж авсан ч данс бүртгэлд тусгах үнэ тодорхойгүй байгаагаас хүлээж авсан хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны 3 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 25 дугаар тогтоолыг үндэслэн Учиртай гурван толгой үндэсний сонгодог дуурийг 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд нийтийн хүртээл болгох зорилгоор Үндэсний их баяр наадмын төсвөөс 600,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Дуурь бүжгийн эрдмийн театрын эзэмшлийн газраас 500 м.кв газар нь бусад байгууллагын эзэмшил газрын кадастрын зурагтай давхардаж байгаагаас газрын гэрчилгээг цахим системд бүртгүүлэх боломжгүй байдал үүссэн, асуудлыг шийдвэрлүүлэхээр хууль, хяналтын байгууллагад хандсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,510,096,788.23	1,752,961,370.37
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	4,650,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	4,650,000.00
33	АВЛАГА	51,341,901.64	52,278,012.29
335	Бусад авлага	51,341,901.64	52,278,012.29
3351	Байгууллагаас авах авлага	51,341,901.64	52,278,012.29
34	УРЬДЧИЛГАА	97,500,000.00	60,730,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	97,500,000.00	60,730,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,361,254,886.59	1,635,303,358.08
351	Түүхий эд материал	6,250,774.98	2,939,779.98
35110	Тусгай зориулалттай материал	6,250,774.98	2,939,779.98
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	13,074,360.00	13,070,360.00
354	Хангамжийн материал	1,341,929,751.61	1,619,293,218.10
35410	Бичиг хэргийн материал	1,210,550.00	145,000.00
35420	Аж ахуйн материал	88,052,076.31	87,319,935.00
35470	Бусад хангамжийн материал	1,252,667,125.30	1,501,920,208.30
35470	Бусад хангамжийн материал	-	29,908,074.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,617,040,889.22	2,527,431,606.17
392	БИЕТ ХӨРӨНГӨ	2,406,675,244.22	2,262,565,961.17
39201	Барилга байгууламж орон сууц	3,128,338,957.19	3,141,338,957.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,048,707,218.61)	(1,256,005,766.01)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	116,920,000.00	116,920,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(99,320,000.18)	(102,520,000.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,407,441,753.43	1,510,678,663.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,245,071,826.19)	(1,324,682,974.35)
39207	Тавилга аж ахуйн эд хогшил	311,554,580.66	369,144,580.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(226,838,268.23)	(249,431,703.60)
39213	Түүх соёл музейн дурсгалт зүйлс	12,715,000.00	12,715,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	351,149,730.00	351,149,730.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(301,507,463.85)	(306,740,525.93)
393	Биет бус хөрөнгө	210,365,645.00	264,865,645.00
39301	Програм хангамж	5,725,000.00	60,225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,725,000.00)	(5,725,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	210,365,645.00	210,365,645.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,127,137,677.45	4,280,392,976.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,127,137,677.45	4,280,392,976.54
51	Засгийн газрын хувь оролцоо	4,127,137,677.45	4,280,392,976.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,684,145,237.49	1,684,145,237.49
512	Хуримтлагдсан үр дүн	(1,423,376,295.32)	(1,270,403,896.23)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,582,829,025.62)	(1,423,376,295.32)
51220	Тайлант үеийн үр дүн	159,452,730.30	152,972,399.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,866,368,735.28	3,866,651,635.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,127,137,677.45	4,280,392,976.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,921,245,474.00	10,928,312,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,921,245,474.00	10,928,312,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,480,470,654.00	8,683,607,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,480,470,654.00	8,683,607,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,440,774,820.00	2,244,704,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	297,990,500.00	788,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого	1,142,784,320.00	1,456,704,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,761,792,743.70	10,775,339,900.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,761,792,743.70	10,775,339,900.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,181,057,271.55	9,848,831,393.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,202,430,911.51	7,101,541,034.59
210101	Үндсэн цалин	3,099,887,161.49	4,351,753,697.94
210102	Нэмэгдэл	954,822,156.44	949,150,646.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	759,156,000.00	1,175,925,000.00
210104	Урамшуулал	388,565,593.58	624,711,690.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	651,377,992.20	876,598,830.02
210201	Тэтгэврийн даатгал	448,677,316.70	602,641,780.91
210202	Тэтгэмжийн даатгал	52,771,897.14	69,651,468.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	41,724,717.70	40,353,708.51
210204	Ажилгүйдлийн даатгал	9,648,549.25	32,329,638.98
210205	Эрүүл мэндийн даатгал	98,555,511.41	131,622,232.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,226,177.71	119,341,461.59
210301	Гэрэл, цахилгаан	54,829,460.67	55,725,706.78
210302	Түлш, халаалт	55,781,276.40	52,970,064.54
210303	Цэвэр, бохир ус	14,615,440.64	10,645,690.27
2104	Хангамж, бараа материалын зардал	48,816,847.53	339,626,673.31
210401	Бичиг хэрэг	5,931,520.00	4,079,100.00
210402	Тээвэр шатахуун	600,000.00	-
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	4,690,471.03	4,628,506.80
210405	Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал ариутгал	5,570,000.00	6,832,000.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	32,024,856.50	231,711,181.51
210408	Бараа материал акталсны зардал	-	92,375,885.00

2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	131,126,500.00	247,329,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,281,000.00	-
210604	Урсгал засвар	128,845,500.00	247,329,750.00
2107	Томилолт зочны зардал	63,022,000.00	14,790,000.00
210702	Дотоод албан томилолт	63,022,000.00	14,790,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	666,582,918.52	831,657,951.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	661,776,005.52	827,859,891.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,202,760.00	2,400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,693.00	153,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	-
210807	Газрын төлбөр	1,244,460.00	1,244,460.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	292,473,924.08	317,945,693.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,200.00	9,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	292,367,724.08	317,936,193.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	580,735,472.15	926,508,506.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	475,195,225.05	726,381,757.61
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	37,990,000.00	47,841,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	103,615,225.05	145,340,757.61
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	333,590,000.00	533,199,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	105,540,247.10	200,126,749.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,866,115.06	145,675,781.23
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	38,674,132.04	54,450,968.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	159,452,730.30	152,972,399.09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	159,452,730.30	152,972,399.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,853,992,274.00	10,955,640,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,853,992,274.00	10,955,640,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,480,470,654.00	8,683,607,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,373,521,620.00	2,272,032,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	297,990,500.00	788,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,075,531,120.00	1,484,032,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	7,673,063,634.00	10,777,163,390.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,673,063,634.00	10,777,163,390.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,092,328,161.85	9,850,154,883.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,218,941,315.86	7,119,822,717.01
210101	Үндсэн цалин	3,320,647,906.99	4,487,676,132.35
210102	Нэмэгдэл	706,985,308.69	828,362,431.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	799,647,961.60	1,174,629,418.70
210104	Урамшуулал	388,565,593.58	629,154,734.77
210105	Гэрээт ажлын хөлс	3,094,545.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	631,623,062.00	889,384,757.97
210201	Тэтгэврийн даатгал	434,088,940.49	610,391,488.70
210202	Тэтгэмжийн даатгал	51,219,200.47	70,137,882.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	40,583,760.48	39,599,488.46
210204	Ажилгүйдлийн даатгал	9,435,105.23	33,592,442.07
210205	Эрүүл мэндийн даатгал	96,296,055.33	135,663,456.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,226,177.71	119,341,461.59
210301	Гэрэл, цахилгаан	54,829,460.67	55,725,706.78
210302	Түлш, халаалт	55,781,276.40	52,970,064.54
210303	Цэвэр, бохир ус	14,615,440.64	10,645,690.27
2104	Хангамж, бараа материалын зардал	38,922,998.03	45,606,466.80
210401	Бичиг хэрэг	5,222,800.00	5,195,050.00
210402	Тээвэр, шатахуун	4,521,000.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,690,471.03	4,628,506.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,228,000.00	4,032,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйл	19,260,727.00	31,150,910.00

2105	Нормативт зардал	7,274,000.00	7,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,274,000.00	7,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	166,416,260.00	277,037,580.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,879,010.00	7,535,700.00
210602	Тавилга	-	7,663,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,306,700.00	-
210604	Урсгал засвар	131,230,550.00	261,838,080.00
2107	Томилолт зочны зардал	54,762,000.00	14,105,851.00
210702	Дотоод албан томилолт	54,762,000.00	14,105,851.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	849,047,448.25	1,375,780,298.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	824,962,772.25	1,366,982,238.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,202,760.00	2,400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,686.00	153,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,032,000.00	-
210807	Газрын төлбөр	622,230.00	1,244,460.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,900.00	2,075,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	114,900.00	2,075,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	580,735,472.15	927,008,506.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	475,195,225.05	726,881,757.61
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	37,990,000.00	47,841,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	103,615,225.05	145,340,757.61
213209	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	333,590,000.00	533,699,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	105,540,247.10	200,126,749.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,866,115.06	145,675,781.23
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	38,674,132.04	54,450,968.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	180,928,640.00	178,476,910.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	180,928,640.00	173,826,910.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	180,928,640.00	173,826,910.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	180,928,640.00	173,826,910.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(180,928,640.00)	(173,826,910.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	4,650,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,650,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,684,145,237.49	3,866,651,635.28	(1,622,548,882.61)	3,928,247,990.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			39,719,856.99	39,719,856.99
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,684,145,237.49	3,866,651,635.28	(1,582,829,025.62)	3,967,967,847.15
Тайлант үеийн үр дүн			159,452,730.30	159,452,730.30
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,684,145,237.49	3,866,651,635.28	(1,423,376,295.32)	4,127,420,577.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,684,145,237.49	3,866,651,635.28	(1,423,376,295.32)	4,127,420,577.45
Тайлант үеийн үр дүн			152,972,399.09	152,972,399.09
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,684,145,237.49	3,866,651,635.28	(1,270,403,896.23)	4,280,392,976.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,683,607,800.00	8,537,932,018.77	145,675,781.23	98.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,683,607,800.00	8,537,932,018.77	145,675,781.23	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,683,607,800.00	8,537,932,018.77	145,675,781.23	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,151,628,200.00	7,050,872,717.01	100,755,482.99	98.6
210101	Үндсэн цалин	4,717,212,000.00	4,487,676,132.35	229,535,867.65	95.1
210102	Нэмэгдэл	874,057,800.00	759,412,431.19	114,645,368.81	86.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,128,600,000.00	1,174,629,418.70	(46,029,418.70)	104.1
210104	Урамшуулал	431,758,400.00	629,154,734.77	(197,396,334.77)	145.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	885,776,200.00	880,766,007.97	5,010,192.03	99.4
210201	Тэтгэврийн даатгал	602,327,900.00	601,772,738.70	555,161.30	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	70,862,100.00	70,137,882.41	724,217.59	99.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	35,431,000.00	39,599,488.46	(4,168,488.46)	111.8
210204	Ажилгүйдлийн даатгал	35,431,000.00	33,592,442.07	1,838,557.93	94.8
210205	Эрүүл мэндийн даатгал	141,724,200.00	135,663,456.33	6,060,743.67	95.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,860,100.00	119,341,461.59	29,518,638.41	80.2
210301	Гэрэл, цахилгаан	72,515,500.00	55,725,706.78	16,789,793.22	76.8
210302	Түлш, халаалт	65,277,500.00	52,970,064.54	12,307,435.46	81.1
210303	Цэвэр, бохир ус	11,067,100.00	10,645,690.27	421,409.73	96.2
2104	Хангамж, бараа материалын зардал	4,700,000.00	4,695,554.59	4,445.41	99.9
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	589,947.79	410,052.21	59.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.00	2,828,506.80	(328,506.80)	113.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,008,000.00	192,000.00	84.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	269,100.00	(269,100.00)	0.0
2105	Нормативт зардал	7,000,000.00	7,000,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,000,000.00	7,000,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	127,576,700.00	122,917,910.00	4,658,790.00	96.3

210601	Багаж техник хэрэгсэл	67,200,000.00	66,621,910.00	578,090.00	99.1
210602	Тавилга	35,376,700.00	31,296,000.00	4,080,700.00	88.5
210604	Урсгал засвар	25,000,000.00	25,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	159,279,100.00	159,080,560.00	198,540.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	153,282,500.00	153,282,500.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,400,000.00	2,400,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	232,100.00	153,600.00	78,500.00	66.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	-	120,000.00	0.0
210806	Газрын төлбөр	1,244,500.00	1,244,460.00	40.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,700.00	75,750.00	36,950.00	67.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,700.00	75,750.00	36,950.00	67.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	198,674,800.00	193,182,057.61	5,492,742.39	97.2
213207	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	47,841,300.00	47,841,300.00	-	100.0
213209	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	150,833,500.00	145,340,757.61	5,492,742.39	96.4
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,683,607,800.00	8,537,932,018.77	145,675,781.23	98.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,683,607,800.00	8,537,932,018.77	145,675,781.23	98.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	8,683,607,800.00	8,537,932,018.77	145,675,781.23	98.3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	285	285		100.0
620001	Удирдах ажилтан	2	2		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	226	226		100.0
620003	Үйлчлэх ажилтан	57	57		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Итгэрэгээр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,267,382,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,267,382,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,679,231,831.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		68,950,000.00
210101	Үндсэн цалин		68,950,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		8,618,750.00
210201	Тэтгэврийн даатгал		8,618,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал		40,910,912.21
210401	Бичиг хэрэг		4,605,102.21
210402	Тээвэр, шатахуун		600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,800,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		3,024,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		30,881,810.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		285,646,580.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		14,850,700.00
210602	Тавилга		33,957,800.00
210604	Урсгал засвар		236,838,080.00
2107	Томилолт, зочны зардал		14,790,000.00
210702	Дотоод албан томилолт		14,790,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,244,209,738.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,241,209,738.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		16,105,851.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		16,105,851.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		588,150,668.13
2132	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		533,699,700.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		54,450,968.13
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,272,032,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,272,032,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		788,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлог		1,484,032,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,650,000.00

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 7,939.1 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Гадаа талбайн машины зогсоол хийх, автомат хаалтын төхөөрөмж суурилуулах ажлын урьдчилгаанд 7,939.1 мянган төгрөг олгосон. Гэрээний дагуу тухайн ажил нь хийгдээгүй байхад урсгал засварын зардлаар хүлээн зөвшөөрч, тайлант оны үр дүнг бууруулсан.	1	7,939.1			1	7,939.1	1	7,939.1				
	Дүн	1	7,939.1			1	7,939.1	1	7,939.1				

3.2 Аудитаар нийт 306,465.2 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс 19,610.0 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 192,755.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 94,100.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
			Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан	Хууль, хяналтын байгууллагад

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

										шаардлага		шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Төрийн банкин дахь кассын харилцах дансанд орсон үзвэрийн төлбөрийг төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй	1	4,650.0	1	4,650.0								
2	Орон нутагт албан томилолтоор ажилласан уран бүтээлчдийн томилолтын зардлыг 6,960.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон	1	6,960.0	1	6,960.0								
3	Мега консалтинг ХХК-тай 2023 онд "Ажил гүйцэтгүүлэх гэрээ" байгуулж, урьдчилгаанд 8,000.0 мянган төгрөгийг гэрээний дагуу шилжүүлсэн боловч тус компани өнөөдрийг хүртэл гэрээт ажлаа гүйцэтгээгүй	1	8,000.0	1	8,000.0								
4	Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан "Учиртай гурван толгой" дуурийг Сүхбаатарын талбайд шинэчлэн тавих ажлын хүрээнд худалдан авалт хийхдээ эрхлэх үйл ажиллагааны чиглэл өөр 5 компаниас 94,100.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн	1	94,100.0					1	94,100.0				
5	ДБЭТ-ын барилгын дотор өрөөнүүдийн урсгал засварын ажил болон уран бүтээлчдийн хувцас худалдан авах зэрэг ижил төрлийн бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулсан	1	178,650.0			1	178,650.0						

6	Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүйгээр халагдсан ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 14,105.2 мянган төгрөгийг байгууллагаас олгосон зардлаар бүртгэсэн	1	14,105.2			1	14,105.2						
	Дүн	6	306,465.2	3	19,610.0	2	192,755.2	1	94,100.0				

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар хариуцлага тоотох 1 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
				Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2024 онд ил тод байршуулбал зохих 8 мэдээллийг, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 39.460.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ, 89,688.0 мянган төгрөгийн зарлагын 8 гүйлгээг тус тус хугацаа хоцроож байршуулсан, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан	1	129,148.0			1	1			
	Дүн	1	129,148.0			1	1			